



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 1/58

Улаанбаатар хот

Нийслэлийн Орон сууцны корпорацн ХК-ны эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн “Орон сууцны корпорацн” ХК-ны эргэлтийн бус хөрөнгөд нийт 19,990,000.00 (арван есөн сая есөн зуун ерэн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хот байгуулалт, хотын стандартын газрын балансад шилжүүлсүгэй.

2.Хавсралтад заасан хөрөнгийг данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн “Орон сууцны корпорацн” ХК (М.Говьсайхан), шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлан бүртгэж авахыг Хот байгуулалт, хотын стандартын газар (Г.Батзориг)-д тус тус даалгасугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг “Орон сууцны корпорацн” ХК (М.Говьсайхан), Хот байгуулалт, хотын стандартын газар (Г.Батзориг)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500512

Нийслэлийн өмчийн харилцааны газрын
2024 оны дугаар сарын...-ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Эд хогшлын нэр	Хэмжих элж	Тоо ширхэг	Ашиглалтад авсан он	Нэгж үнэ	Нийт үнэ	Үлдэх өртөг	Эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэн авах байгууллага
1	Дрон (үзүүлэлт: хөөрөх жин-1110 гр, нислэгийн минут 42, видео нягтрал 6к 572*3076, р30/р25/р24, мэдрэгч 1 CMOS 20mp, тогтворжуулагч 3 тэнхлэг, хамгийн их зай 27 км)	Ш	1	2024	19,990,000.00	19,990,000.00	19,990,000.00	Нийслэлийн Орон сууцны корпораци ХК	Хот байгуулалт, хотын стандартын газар
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн							19,990,000.00		